



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreatkhural@parliament.mn](mailto:stategreatkhural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2025.01.14 № 02

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр  
эрхлэлтийг дэмжих талаар

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт илт буурч, ажиллах хүчний оролцооны түвшинд жендэрийн ялгаатай байдал бий болсон нь цаашид нийгэм, эдийн засгийн ноцтой үр дагавар дагуулахаар байна.

Тухайлбал, 2023 оны байдлаар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 51.9 хувь байхад эрэгтэйчүүдийнх 67.9 хувь байгаа юм. 2009 оноос ажиглагдаж эхэлсэн энэхүү жендэрийн зөрүүтэй байдал огт арилахгүй байгаа явдалд дүн шинжилгээ хийж, төрийн бодлогын хүрээнд тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан дэмжих талаар салбарын яамнаас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн тухай мэдээлэл;
2. 2016 оноос эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, холбогдох тайлан, дүгнэлт;
3. 2016 оноос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй нийтлэг арга хэмжээ, төсөл хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрхэн туссан талаарх мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.ЖАРГАЛАН

2025000004